

## ЧИНГИС ХААНЫ ЗООСОН МӨНГӨНИЙ ТУХАЙ

**Б.НЯМАА**

*Зоос судлаач*

*e-mail: Lhanaa@hotmail.com*

*Түлхүүр үгс: Монголын эзэнт улс, Их хаан, алтан зоос, мөнгө, зэс зоос, тамга, Хорезм, Багдад, Бухаар, Хан, Хаан, Хагаан, Астарабад, Газни*

**ТОВЧ АГУУЛГА:** *Монголын эзэнт улсын зоосон мөнгө нь түүхийн чухал сурвалж, он цагийн бодит хронолог болохын хувьд зайлшгүй судлах шаардлагатай түүх, бичиг соёлын үнэт дурсгал мөн билээ. Чингис хааны 20 орчим төрлийн алт, мөнгө, зэс зоосон мөнгө мэдэгдэж байгаагийн дотор их хааны нэр алдрыг дурдсан зоос хэд хэдэн төрөл байна. Чингисийн зоосон мөнгийг хийсэн материалаар нь болон дээрх бичээсээр доорх хэдэн төрөлд ангилж болохоор байна.*

- 1. “Хаад хаадын дотроос хамгийн аугаа нь Чингис хаан”, “Аугаа Их Чингис хаан” гэсэн бичээс бүхий алтан динар*
- 2. Чингис хааны нэр болон онгин тамга сийлсэн мөнгөн динар*
- 3. Чингис хааны нэрийг бичсэн мөнгөн дирхам (Газни)*
- 4. “Аугаа Чингис хааны зарлигаар” гэсэн бичээстэй зэс зоос.*
- 5. Хагаан, Хаан гэсэн бичээстэй зэс зоосууд*

Монголын эзэнт улсын зоосон мөнгө нь түүхийн чухал сурвалж, он цагийн бодит хронолог болохын хувьд манай түүх, бичиг соёлын үнэт дурсгал билээ. Монголын эзэнт улсын түүхийн судлал, ялангуяа Чингис судлалын дотор их хааны зоосон мөнгөний асуудал хамгийн бага судлагдсан сэдэв юм. Энэ нь юуны өмнө Монголын эзэнт улсын мөнгөний тухай судлал харьцангуй хожуу эхэлж, судалгааны материал олон жилийн турш хомс байсантай холбоотой байна. Монголын албан ёсны түүх бичлэгт эзэнт улсын мөнгөний тухай, ялангуяа Чингис хааны мөнгөний тухай тодорхой мэдээлэл ороогүй байсаар байгааг бодохул энэ асуудлыг нухацтай судалж, гаргаж тавих шаардлагатай болсон гэж бодогдож байна. Монголын эзэнт улсын үеийн эдийн засгийн байдал, мөнгөний бодлого зэрэг асуудлыг судлахад эзэнт улсын үеийн мөнгө, мөнгөний эргэлт, ханш, болон үүнтэй холбоотой олон асуудлаар хийсэн бодит судалгаа зайлшгүй шаардагдана. Нөгөөтэйгүүр монголын хаадын судлал, тэр тусмаа Чингис судлалын хүрээнд Чингис хааны мөнгөний тухай мэдээлэл бага байгаагаас зарим нэгэн төөрөгдөл, эндүүрэл ч гарч байна. Тухайлбал, зарим судлаачдын бие даан хийсэн судалгаан дотор өөр улсын ердийн нэгэн билэгдлийн чанартай зоосыг Чингисийн алтан зоос

мэтээр эндүүрсэн ном зохиол хүртэл гарч байв. (Чунт, 2005: 15-30; Хэ Линь ба бусад, 2003). Энэхүү билэгдлийн зоос нь Хятадын Хэ Линий каталогийн 217-р талд № 196-д бүртгэгдсэн байдаг. Хятад хэл дээрх тайлбарыг хөрвүүлбэл: “Дорнын зурхайн билэгдлийн гуулийн зоос. Нүүрэн талд: Гол дунд амьтан, шувуудын дүрс бүхий угалз маягийн зүйл байна. Гаднах хүрээгээр дорнын зурхайн ордын 12 амьтныг дүрсэлжээ. Ар талд: Тэнгэрийн багш Жан гартаа ид шидийн аяга барьж, шидэт илдээр даллаж буйг үзүүлжээ. Зүүн талд нь жижгэвтэр дүрс байгаа нь чөтгөр шулам бололтой байх бөгөөд мөн биен дээр нь даоизмын хараал тэмдэглэсэн ямар нэгэн бузрын амьтны дүрс үзэгдэнэ. Диаметр 6,36 см, гадна талын хүрээний өргөн 0,25 см<sup>1</sup> гэжээ.

Чингис хаан Дундад Ази, Хорезмыг эзэлснээс хойш буюу 1221-1227 онд түүний алдар нэрийг бичсэн алт, мөнгөн зоосыг Дундад Ази, Хорезмийн томоохон хотуудад гаргажээ. Ер нь хааны нэртэй зоос гаргаж тодорхой нутаг дэвсгэрт гүйлгэнэ гэдэг нь тухайн улс орон, хүн ам, газар нутаг нь бүхэлдээ тэр хааны харъяат эзэмшил болохын албан ёсны илэрхийлэл, нэгэн чухал баталгаа нь болж байлаа. Ийм байдлаар Хорезмд Чингис хааны нэр, тамгатай зоос гарсан нь Чингис хаан Хорезмийг байлдан дагуулсан, тухайн үедээ тэр газрыг эзэгнэх болсон гэдгийн илэрхийлэл болж байгаа юм. Чингис хааны нэртэй алтан зоосон дээр арабаар “Хаад хаадын дотроос хамгийн аугаа нь Чингис хаан мөн” (Нямаа, 2005: 117) хэмээн бичсэн байсан бол мөнгөн зоосон дээр “Аугаа их эзэн Чингис хаан” (Нямаа, 2005: 155), зэсээр хийсэн зоосон дээр “Их Хаан” (Нямаа, 2005: 156-57) хэмээн тус тус бичсэн байлаа. Энэ бол Их Монгол улсын түүхэнд мэдэгдэж байгаа хамгийн эхэн үеийн зоосууд бөгөөд Чингис хааныг амьд сэрүүн байхад гарсан зоос болохын учир Чингис судлалд ихээхэн ач холбогдолтой сурвалж болох юм.

Ийнхүү 1220-иод оноос монголчууд зоосон мөнгөө гаргаж улмаар Хорезмын шахуудын зоосон мөнгийг гүйлгээнээс шахан, оронд нь монголын Их хаадын зоосон мөнгийг эргэлтэнд оруулж эхэлсэн бөгөөд Хорезмд төлбөр тооцоо, шан харамж, алба гувчуур, худалдаа арилжаанд зөвхөн монголын зоосыг хэрэглэх болжээ. Гэвч энэ асуудал тийм амархан хэрэгжээгүй юм.

Олон зууны туршид араб хэл, соёл, исламын шашны ёс заншил тогтнож ирсэн энэ өргөн уудам нутгийн оршин суугчид дайлаар эзэлсэн харийн монголчуудад талтай байгаагүй нь мэдээж. Хорезмийн хаант улс нь тухайн үедээ худалдаа, эдийн засгийн хөгжлөөр ихээхэн хүчирхэг улсын нэг байсан бөгөөд Европ- Азийг холбосон худалдааны томоохон зангилаа, торгоны замын гол гарц болж байлаа. Бухар, Самарканд, Мерв, Термез, Тараз, Ургенч, Балх, Күндүз, Герат,

<sup>1</sup> Данный китайский зодиакальный амулет приведен под номером 217 на стр. 196 в каталоге Хэ Линя. Перевод описания данного амулета с китайского языка:

“Зодиакальный амулет, бронза, старая патина. Аверс: центральная часть - похожа на узор со зверями и птицами. Внешняя часть - двенадцать зодиакальных животных. Реверс: Небесный Учитель Чжан манипулирует волшебным мечом, держа в руке чашу для магических действий. Слева небольшая фигурка, вероятно, черта или какой-то другой нечистой силы, а также некое извивающееся существо, на теле которого видны даосские магические заклинания. Диаметр 6.36 см, толстый бортик 0.25 см”.

Түс, Нишапур, Шираз, Газни зэрэг гоёмсог сайхнаараа алдартай хотууд нь дорно зүгийн тансаг торго дурдан, сувд эрдэнэс, үнэт чулуу, элдэв амттан зэргээс эхлээд европын газар газрын ховор бараа зөөсөн олон орны худалдаачид хөлхөлдсөн цэцэглэн хөгжсөн их хөлийн газар байв.

Энд Хорезмын шахын алтан динар тэргүүтэн зоосон мөнгөөр худалдаа арилжаа хийдэг байсан бөгөөд энэ нь гадаадын худалдаачид болон ард олны дунд нэр хүнд сайтай, тэдний хэрэглэж заншсан, баталгаатай хэмээн өндөр үнэлэгдсэн мөнгө байлаа. Ийм нөхцөлд таньж мэдэхгүй харийн монголчуудын зоосон мөнгийг гүйлгээнд оруулах нь тийм ч амар байсангүй. Нутгийн хүн ам, ялангуяа худалдаачдын дотор монголын хааны мөнгийг хэрэглэх нь эрсдэлтэй тул Хорезмын болон бусад улсуудын мөнгийг хэрэглэх эсвэл алт, мөнгөөр гүйлгээ хийх нь илүү баталгаатай хэмээн үзэх хандлага хүчтэй байв. Иймд монголын хаад өөрсдийн мөнгийг гүйлгээнд хурдан бөгөөд өргөнөөр нэвтрүүлэхийн тулд Хорезмын зоосыг гүйлгээнээс гаргахын зэрэгцээ орон нутгийн урчууд дархчууд, зоосон мөнгө үйлдвэрлэгч нарыг цуглуулан монголын мөнгийг олон хот сууринд шаардлагатай хэмжээгээр үйлдвэрлэж байв. Мөн зоосны хэв загварыг Хорезмын зоостой төстэй байдлаар хийх, зоосны бичээсийг тэдний сайн мэдэх араб хэлээр үйлдэж, Коран судрын Калима хэмээх уншлага, Багдадын Халиф Насирын нэр алдар тэргүүтэнг сийлж байсан нь нэг талаас нутгийн иргэдэд монголын мөнгийг хэрэглэж дасгах, тэднийг татахад чиглэсэн арга хэмжээ байсан бололтой. Нөгөө талаас монголчуудын тэр үеийн мөнгө нь эртний арабын томоохон династи болох Аббасид, Сэлжүүк, Фатимид, Хорезмын Шахуудын зоосыг хуулбарлаж дууриалган хийсэн шинжтэй байдаг нь монголчуудад өөрсдийн мөнгө үйлдвэрлэх уламжлал туршлага байгаагүйгээс шалтгаалсан тал бий. XIII-XIV зууны монголын эзэнт улсын хаадын зоосон дээр исламын шашны Калима хэмээх маанийг бичдэг байсан нь арабын орнуудад эртнээс тогтож ирсэн уламжлал байсан бөгөөд тэр үед исламын шашин, соёлын нөлөө маш хүчтэй байсны зэрэгцээ дайлаар очсон монголын зарим хаадууд исламын шашныг таашаан үзэж улмаар ислам шашинтан болж байсантай холбон үзвэл зохино.

Монголын хаадын зоосыг гүйлгээнд оруулж хэвшүүлэхэд чиглэгдсэн дээр дурдсан зарим арга хэмжээг авч байсан хэдий ч “дургүйд хүчгүйн” үлгэрээр монголын мөнгөнд үл итгэх, үл хайхрах буюу хэрэглэхээс татгалзах явдал төдийлөн арилаагүй тул зарим газар хүчээр тулгах, албадах, тэрч байтугай сүрдүүлж заналхийлэх ч арга хэрэглэж байжээ. Тухайлбал, Самарканд хотод гаргасан зарим зоосон дээр монголын зоосыг үл хэрэгссэн хүнийг “цэргийн албанд албадан явуулна”, “гэмт этгээдэд тооцно” (Spingler, 1996) гэхчлэн сүрдүүлэн бичсэн байдаг нь үүнтэй холбоотой юм.

Иймэрхүү байдлаар анх эхэлж байсан Их монгол улсын зоосон мөнгө аажмаар улам бүр хүчирхэгжих болсноор барахгүй XIV зууны дунд үе гэхэд Монголын Эзэнт Гүрний 380 гаруй хотод монголын хааны нэр цол, хаанчлалын он цаг, газар орныг тодорхой бичсэн зоосон мөнгө гаргаж, Европ Азийг дамнасан өргөн уудам орон зайд гагцхүү монголын мөнгө үйлчилж байсан түүх үлджээ.

Чингис хаан Их Монгол улсыг байгуулсан шигээ Монголын Эзэнт Гүрний мөнгөний түүхийн анхны шанг татсан гавьяатай юм. Чингис хаан 1219 онд Хорезмыг дайлаар мордож, түүний их цэрэг дээр дурдсан том хотуудыг ээлж дараалан эзэлж Хорезмын хаант улсыг мөхөөсөн нь тухайн үед Их Монгол улс, Чингис хааны бодлого, зорилгын хувьд маш чухал ач холбогдолтой, Монголын Эзэнт Улс байгуулагдах эхлэл тавигдсан түүхэн том үйл явдал байлаа. Энэ үед Монголын эзэнт улсын мөнгөний түүхэнд хамгийн анхны хэмээн тооцогдож болох зоосон мөнгө гарсан байх ба энэ нь Чингис хааны нэр алдрыг бичсэн алт, мөнгөн зоосууд байжээ. Эндээс Чингис хааны алтан зоосыг зөвхөн гүйлгээний зорилгоор гаргасан уу, эсвэл өөр зорилготой байв уу гэсэн асуулт урган гарч болох юм.

Судалгаанаас үзвэл Чингис хааны зоосны дотроос мөнгө болон зэс зоос харьцангуй олон олдсон байхад алтан зоос маш цөөн үзэгдэж байгаа бөгөөд ялангуяа хааны нэртэй алтан зоос 100 орчим тоотой мэдэгдэж байгаа нь дэлхийн хэмжээнд ховор зоосны төрөлд багтах үндэслэл болно. Ийм цөөн тоотой байгаагийн нэг шалтгаан нь тухайн үедээ энэ төрлийн зоосыг зориуд цөөн хувь гаргасантай холбоотой байж болно. Аль ч үед, аль ч улс оронд гүйлгээний мөнгийг зөвхөн алтаар хийх боломж бараг байхгүй бөгөөд ашиггүй тул их төлөв мөнгө болон зэсээр хийж ирсэн байдаг. Алтаар хийсэн зоосыг нийт гаргаж байгаа мөнгөний багаахан хувьтай тэнцүүлэн хийх, эсвэл тусгайлан зориулж гаргах нь түгээмэл байв.

Тухайн үедээ үлэмж хүчирхэг байсан Хорезмыг эзэлсэн нь Чингис хааны нэр алдрыг мандуулсан түүхэн ялалт, их улс байгуулах зорилтыг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн чухал үйл явдал байлаа. Аливаа ялалтыг хэзээ ямагт ямар нэгэн байдлаар тэмдэглэж ирсэн уламжлал бий. Энэ үүднээс бодвол Хорезмыг мөхөөсөн ялалтыг ч мөн өргөн тэмдэглэсэн гэж үзэх үндэстэй бөгөөд үүний нэг хэлбэр нь тухайн ялалтыг тэмдэглэж Чингис хааны нэр алдрыг магтсан бичээс бүхий алтан зоосыг харьцангуй цөөн тоогоор гаргасан явдал байж болох юм. Иймд Чингис хааны алтан зоосыг дан ганц гүйлгээний зорилгоор гаргаагүй харин тухайн их ялалтыг тэмдэглэж цөөн тоогоор гаргасан, нумизматикийн ойлголтоор бол дурсгалын алтан зоос байдлаар гаргасан бололтой гэж үзэж болох юм.

Чингис хаанд шууд хамаарах 20 орчим төрлийн зоос мэдэгдэж байгааг судалж үзэхэд эдгээр нь дотроо үндсэн 5 хэлбэртэй байна.

1. Чингис хааны нэрийг бичсэн алтан динар (Газни, Самарканд, Бухар, Астарабад)
2. Чингис хааны нэр болон онгин тамга сийлсэн мөнгөн динар (Самарканд)
3. Чингис хааны нэрийг бичсэн мөнгөн дирхам (Газни)
4. “Аугаа Их Чингис Хааны Зарлигаар” гэж тодорхойлсон бичээстэй зэс зоос
5. 1221-1227 онуудад гарсан Хагаан, Хаан гэсэн бичээстэй зэс зоосууд (Газни, Мерв, Күндүз, Куррамань Нимрүз зэрэг )

Үүнээс гадна чухам хэдийд, ямар хааны үед гарсан болох нь гүйцэд тогтоогдоогүй, монголын их хаадын үеийн нилээд хэдэн төрлийн зоос олноод байгаагийн заримыг судлаачид Чингис хааных гэж үздэг явдал бий боловч сайтар тодруулах шаардлагатай болохын учир энэ өгүүлэлд тэдгээрийн тухай оруулсангүй.

Чингис хааны зоосон мөнгийг дээр дурдсан ангиллын дагуу тус тусад нь зургаар үзүүлж, зоосон дээрх бичээсийн тайлбар хийснийг дор үзнэ үү.

## 1. ЧИНГИС ХААНЫ НЭРИЙГ БИЧСЭН АЛТАН ДИНАР

Зураг 1.



Энэ алтан зоосыг хижрийн 618 онд буюу 1221 онд Газни (одоогийн Афганистан) хотод дэлдүүлжээ. 1996 онд Газни хотоос археологийн малтлагын үед олджээ (Spingler, 1996).

Каталог № А-1964

Хэмжээ: 23 мм, 3.23 гр.

Нүүрэн талд: **Хаад хаадын дотроос хамгийн Аугаа нь Чингис хаан**  
(Al Khagaan / Al-a'dl / Al – a'zm / Chingiz Khan)

Ар талд: **Аллахаас өөр бурхан үгүй. Их Насир бол сүсэгтнүүдийн**  
**жолоодогч мөн.**

(La ilaha Illa Allah/ Muhammad Rasul Allah An Nasir Li Din Allah /  
Amir Al Mu'minin )

Хүрээний бичээс: **Энэ динарыг 618 онд Газнид дэлдүүлэв**

*\*Ар талд байгаа бичээс нь Коран судрын ишлэл бөгөөд ислам шашинтнуудын Калима хэмээх уншлага юм. Энэ уншлагыг исламын шашинт бүх улс орнуудын зоосон мөнгөн дээр тавьдаг уламжлалтай байсан бөгөөд монголын эзэнт гүрний ихэнх зоосны ар талд бичсэн байдаг нь тухайн үедээ улс төр, эдийн засаг, шашны учир шалтгаантай байжээ. Цөөн тохиолдолд Халиф Насирын нэртэй хамт бичсэн байх бөгөөд ихэвчлэн дангаар нь бичдэг уламжлалтай байжээ. Цаашид товчлон Калима хэмээн нэрлэнэ.*

Зураг 2.



Энэ зоос нь Зураг 1-д үзүүлсэн зоостой адил Газни хотод дэлдүүлсэн боловч зоосны хэв, бичээсийн хэлбэр маяг, үгсийн байршил зэргээрээ ялгаатай байгаа нь Чингисийн энэхүү алтан зоосыг хэд хэдэн газар, өөр өөр хэв цутгаж хийсэн

болохыг харуулж байна. Тайлбар нь дээрхтэй адил болно. Хувь хүний цуглуулгад байсныг 2007 онд АНУ-ын Нью Йорк хотод явагдсан олон улсын эртний зоосны 14-р дуудлага худалдаагаар арилжжээ.

Зураг 3.



Хижрийн 618 онд буюу 1221 онд Бухаар (одоогийн Узбекистан улс) хотод дэлдүүлсэн алтан зоос. Он цагийг бичээгүй буюу бичсэн нь баларч үрэгдсэн бололтой.

Каталог № А-1964.

Хэмжээ: 22.5 мм, 3.36 гр

Нүүрэн талд: **Аугаа Их Эзэн Чингис хаан**  
(Chingiz Khan / Al- a'dl / al- a'zm)

Ар талд: **Бухара хот / Калима**

Зураг 4.



Хижрийн 618 онд буюу 1221 онд Самарканд (одоогийн Узбекистан) хотод дэлдүүлсэн алтан зоос. Зоосон дээрх он цаг болон хийсэн газрын нэртэй хэсгийг зориуд тайрч авсан нь илэрхий байгаа бөгөөд ийнхүү тайрах буюу баллах явдал тэр үед ихээхэн тохиолддог байжээ. Гэвч зоосны бичээсийн хэв маягаас харахад Самаркандын хийцтэй байгаагаас судлаачид энэ зоосыг Самаркандад дэлдүүлсэн гэж үзэж байгаа.

Каталог № А-1964

Хэмжээ: 22 мм, 4.89 гр

Нүүрэн талд: **Аугаа Их Эзэн Чингис хаан**  
(Chingiz Khan / Al- a'dl / al- a'zm)

Ар талд: **Калима**



Зураг 5.



Астарабад (одоогийн Иран) хотод дэлдүүлсэн алтан динар. Он цаг нь балархайтсан бололтой.

Каталог № А-1964

Хэмжээ: 22 мм, 2.60 гр

Нүүрэн талд: **Аугаа Их Эзэн Чингис хаан** (Астар абад)

**(Astar Abad /Chingiz Khan/ Al- a'dl / al- a'zm)**

Ар талд: **Калима**

## 2. ЧИНГИС ХААНЫ НЭР БОЛОН ОНГИН ТАМГА СИЙЛСЭН МӨНГӨН ДИНАР

Зураг 6.



Чингис хааны мөнгөлсөн зэс зоос. Самарканд, 1227 он

Нүүрэн талд: **Ширээтэй онгин тамга**, түүний дор **нуман тамга** байх ба түүнийг тойруулан дөрвөлжин хүрэн дотор **“Самарканд хот ба түүний орчимд гүйх зоос”** гэж бичсэн.

Ар талд: Гурван мөр бичээстэй ба энэ нь **“Чингис хаан, Чингисийн мөнгө”** гэсэн үгс байна (Давыдович, 1972: 132; Нямаа, 2005: 168; Лихачев, 1928: 149).

Тойрсон хүрээнд: **624 он** гэсэн нь **1227 он** болно.

Энэхүү зоосон дээр “Чингис хааны мөнгө” гэж бичээд онгин тамга сийлсэн байгаа нь хоорондоо учир холбогдолтой гэдэг нь хэн ч харсан маш ойлгомжтой байгаа юм. Чухам энэ зоосны бичээс, тамга хоёрыг баримтлан эртний монгол овогтны тамганы нэг болох Онгин тамга нь Чингис хааны овгийн тамга байжээ гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Чингисийн зоосон дээрх энэ онгин тамга түүний ахмад хүү Зүчийн удам буюу Алтан Ордны улсын бараг бүх хаадын зоосны

тамганд уламжлагдсан байдаг нь уг тамга Чингис хаанд хамаатай болохын нэгэн нотологоо болж байна. Энэхүү онгин тамга Цагаадай, Өгөөдэй, Толуйн удмын олон хаадын зоосон дээр өөр өөрийн өвөрмөц хэлбэртэйгээр уламжлагдсан байдгийг зориуд тэмдэглэе. Үүнтэй адил байдлаар өөр бусад олон хаадын тамгыг Монголын эзэнт Гүрний зоосон дээрээс олж харж болно. Үүнийг илүү ойлгомжтой болгох үүднээс бас нэгэн жишээг авч үзүүлье.

Зураг 7.



Энэ зоосны нэг талд бундан тамга байх ба тойрсон хүрээнд **“Чагатай йарли”** гэсэн үг байгаа нь Цагаадайн зарлиг гэсэн үг бөгөөд гол дунд байх бундан (гилбэр) тамга түүний овгийн тамга гэж үзэх үндэстэй байна. Учир нь Цагаадайн хожмын удам залгамжлагчдын гаргасан зоосон мөнгөн дээр их төлөв гилбэр буюу гилбэрээс үүсгэсэн тамга сийлсэн байдаг нь энэхүү гилбэр тамга Цагаадайнх гэдгийг давхар харуулж байгаа нэг нотолгоо мөн. Тэгвэл уг зоосны нөгөө талд **“Окатай йарли”** гэж бичээд Дэгэрэ буюу зуузай тамга сийлжээ. Окатай гэдэг нь Өгөдэй хааныг хэлж байгаа хэрэг бөгөөд дэгэрэ тамга мөн Өгөдэй хааных юм. Өгөдэйн удмын Хайду, Али Султан зэрэг хаадуудын ихэнхи зоосон мөнгө дэгэрэ, эсвэл дэгэрэ тамгаас үүсгэмэл тамгатай байдаг нь тэдгээрийн тамга нэг үндэстэй болохыг харуулж байна. Эдүгээ энэ зоос Оросын Эрмитажид цорын ганц хувь хадгалагдаж үлджээ (Лихачев, 1928: 149).

Мөн 2002 онд Хар Хорины малтлагаас олдсон мөнгөн зоос дээр **“Хар Хорум. 637 (1238)”** гээд дэгэрэ тамга тавьсан байсан нь чухамдаа Өгөдэй хааны үе мөн бөгөөд дэгэрэ тамга Өгөдэйнх гэдгийн бас нэг нотолгоо болно. Энэ мэтээр Монголын эзэнт улсын олонх хаадын овгийн тамгыг тэдний зоосон мөнгөнөөс олж тогтоох боломж байгаа ба энэ дагуу зохих судалгааны ажил хийгдэж байна.

Зураг 8.





Чингис хааны мөнгөлсөн зэс. Самарканд, 1225 он

Нүүрэн талд: Дээрх зоостой адил ширээтэй онгин тамга байх ба харин түүний түүний дор таван нүдэт өлзий тамга харагдана. Тойруулсан дөрвөлжин хүрэн дотор “Самарканд хот ба түүний орчимд гүйх зоос” гэжээ.

Ар талд: Жижиг дугуй хүрээнд Самарканд хэмээн бичсэн байгаа ба тойруулан “622 онд дэлдүүлэв” гэжээ. Энэ нь 1225 он болно. Гэвч Чингисийн мөнгө гэдэг үг байхгүй.

Зураг 9.



Чингис хааны мөнгөлсөн зэс. Самарканд, 1225 он

Нүүрэн талд: Дээрх зоостой адил ширээтэй онгин тамга ба таван нүдэт өлзий тамгатай. Тойруулан дөрвөлжин хүрэн дотор “Самарканд хот ба түүний орчимд гүйх зоос” гэж бичжээ.

Ар талд: Дээрхээс зарим ялгаатай байна. Чингисийн мөнгө гэсэн бичээс байхгүй. Дээр үзүүлсэн зоосны ар талын гол дунд Самарканд гэсэн үгтэй жижиг дугуй хүрээ байдаг бол энэ зоосны ар талын гол хэсэгт том таван нүдэт өлзий тамга сийлжээ.

Харин тойруулан “622 онд дэлдүүлэв” гэсэн нь дээрхтэй адил буюу 1225 онд дэлдүүлсэн гэсэн үг юм.

### 3. ЧИНГИС ХААНЫ НЭРИЙГ БИЧСЭН МӨНГӨН ДИРХАМ (ГАЗНИ)

Зураг 10.

Нэг дэх хэлбэр.



Чингис хааны мөнгөн дирхам хэмээх зоос. Уг зоосон дээр дэлдүүлсэн он цаг, газар орны нэрийг бичээгүй боловч Хорезм шахын үед Газни хотод гаргаж байсан

ЧИНГИС ХААНЫ ЗООСОН МӨНГӨНИЙ ТУХАЙ

зоостой хийц хэлбэрийн хувьд ихээхэн төстэй байгааг үндэслэн 1221 онд Газни (одоогийн Афганистан) хотод гаргасан зоос гэж тогтоожээ.

Каталог № А-1967.

Хэмжээ: 18 мм, 3.12 гр.

Нүүрэн талд: **Аугаа Их Чингис хаан**

(Al- A'dl / Al-A'zm/ Chingiz Khan)

Ар талд: **Аббасидын Багдад дахь Халиф Насирын нэр цолыг бичжээ.**

**\*\*Чингис хааны мөнгөн дирхэм зоос хийцийн хувьд 4 өөр байгаа бөгөөд энэ зоосны нүүрэн талын гол дунд нэг, зүүн талдаа гурван цэгтэй байгаа нь ялгагдах онцлог юм.**

Зураг 11.

**Хоёр дахь хэлбэр**



Чингис хааны мөнгөн дирхам хэмээх зоос.

Каталог № А-1967.

Хэмжээ: 17 мм, 2.9 гр.

Нүүрэн талд: **Аугаа Их Чингис хаан”**

(Al- A'dl / Al-A'zm/ Chingiz Khan)

Ар талд: **Аббасидын Багдад дахь Халиф Насирын нэр цолыг бичжээ.**

**\*\*Нүүрэн талын гол дунд гурван цэгтэй хэлбэр**

Зураг 12.

**Гурав дахь хэлбэр.**



Чингис хааны мөнгөн дирхэм хэмээх зоос.

Каталог № А-1967.

Хэмжээ: 18 мм, 3.0 гр

Нүүрэн талд: **Аугаа Их Чингис хаан**

(Al- A'dl / Al-A'zm/ Chingiz Khan)

Ар талд: **Аббасидын Багдад дахь Халиф Насирын нэр цолыг бичжээ.**

*\*\*Нүүрэн талд Чингис хааны нэрийг бичсэн байдал нь бусад хэлбэрээсээ ялгагдана, ямар нэгэн нэмэгдэл цэг тэмдэг байхгүй, ар тал дахь хүрэнүүдийн хооронд байгаа цэгүүд жижигхэн байдаг онцлогтой.*

Зураг 13.

**Дөрөв дөх хэлбэр.**



Чингис хааны мөнгөн дирхэм хэмээх зоос.

Каталог № А-1967.

Хэмжээ: 15 мм, 2.4 гр

Нүүрэн талд: **Аугаа Их Чингис хаан**

**(Al- A'dl / Al-A'zm/ Chingiz Khan)**

Ар талд: **Аббасидын Багдад дахь Халиф Насирын нэр цолыг бичжээ.**

*\*\*Нүүрэн талд Хаан гэдэг үгийг бичсэн байдал нь өвөрмөц, мөн зоосны жин хэмжээ бусад хэлбэрүүдээс ялгаатай байдаг онцлогтой.*

Зураг 14.



Чингис хааны мөнгөлсөн зэс зоос. Дэлдсэн он, газрын нэр байхгүй боловч Газнигийн зоосны хийцтэй. Энэ зоос бол **“АУГАА ИХ ЧИНГИС ХААНЫ ЗАРЛИГААР”** гэсэн бичээстэй байдгаараа бусад зоосноос онцлог юм.

Каталог № А-1968. RRR.

Хэмжээ: 29 мм, 2.5 гр

Нүүрэн талд: **“Аугаа Их Чингис Хааны Зарлигаар”**

**(Bifarman / Al Hagaan / Muazam / Chingiz Khan)**

**(By the Decree of the Great Chinggis Khan)**

Ар талд: Калима

#### 4. 1221-1227 ОНУУДАД ГАРСАН ХАГААН, ХААН ГЭСЭН БИЧЭЭСТЭЙ ЗЭС ЗООСУУД (ГАЗНИ, МЕРВ, КҮНДҮЗ, КУРРАМАН ЗЭРЭГ ХОТУУД)

Дээр дурдсан зоосууд нь тодорхой эзэнтэй буюу Чингис хааны нэр цолыг бичсэн хэлбэрүүд юм. Эдгээрээс гадна Их хааны нэрийг бичээгүй боловч Чингис хааны үед хамаарах нилээд хэдэн төрлийн зоос мэдэгдэж байгаа нь дэлдүүлсэн он цагаараа хэнийх болох нь тогтоогддог, хааны нэрний оронд зөвхөн “Хагаан”, ”Хаан” гэх мэтээр бичсэн байдаг онцлогтой зооснууд болно. Тухайлбал, 1206-1227 оныг дуустал Их Монгол улсад, эсвэл монголын байлдан дагуулсан улс оронд монголчуудын гаргасан зоос тодорхой нэргүй байсан ч он цагийн хувьд зөвхөн Чингис хаанд хамаарах ёстой ба харин 1227 оноос хойших зооснууд түүнд хамаарахгүй юм. Жишээ нь, 1227-1241 онд Өгэдэй Их Монгол улсын хаан ширээнд суусан тул тэр цаг үед гарсан зоос нэргүй, тамгагүй байсан ч Өгэдэй хаанд хамааруулж үзнэ.

Чингис хааны үед гарсан нэргүй зоосыг алт, мөнгөөр хийхээс гадна мөнгөлсөн зэс болон цэвэр зэсээр хийж байв. Ийм зоос нилээд хэдэн төрөл байгаагийн заримаас толилуулбал:

Зураг 15.



Чингис хааны зэс зоос. Дэлдсэн он, газрын нэр бичигдээгүй, гэвч Газни хотын зоосны хийцтэй байгаа ба 1221-1227 оны хооронд гарсан бололтой байдаг.

Каталог № А-В 1973. RRR (нэн ховор),

Хэмжээ: 15 мм, 3.0 гр

Нүүрэн талд: Дөрвөлжин хүрээн дотор арабаар “**KHAGAN**” гэж бичсэн нь монгол хэлний “**ХААН**” гэсэн үг юм (Нямаа, 2005: 156).

Ар талд: “**Adl**” хэмээх араб үг байх ба үүнийг монгол хэлнээ утгачилбал “хууль, хууль ёсны, засаг барих эрхэм дээдэс” гэсэн үг үг бөгөөд зоосны хоёр талын бичээсийг нийлүүлэн уншвал “**Их Хаан бол Хууль**” гэсэн утгатай болно.

Монголын зоосон дээр хаадын алдар цолыг бичихдээ Хагаан, Хаан, Хан хэмээн гурван янзаар бичдэг байсан ба Их хаадыг нэрлэхдээ “Ал Хагаан” эсвэл “Ка-ан” гэдэг байв. Иймд Хагаан гэсэн бичээстэй дээрх зоосыг тухайн үедээ цорын ганц Их Хагаан байсан Чингис хааных мөн гэж судлаачид үзсэн байна.



Зураг 16.



Чингис хааны мөнгөлсөн зэс зоос. Дэлдсэн он цаг, газрын нэр байхгүй. 1221-1227 он. Газнигийн хийцтэй.

Каталог № А-1969.

Хэмжээ: 32 мм, 4.4 гр

Нүүрэн талд: Эхний мөрөнд “Хагаан” гэж бичсэн байгаа ба түүнээс дооших мөрүүдэд Багдадын Халиф Насирын нэр цолыг дурджээ.

Ар талд: Калима

Зураг 17.



Чингис хааны үеийн зэс зоос. Хижрийн 618 он буюу 1221 онд Күндүз хотод (тэр үеийн Хорезм, одоогийн зүүн хойт Афганистан) дэлдүүлжээ.

Каталог № А-1972, Тайгийн каталог #334.1, MWI-914.

Хэмжээ: 22 мм, 4.6 гр

Нүүрэн талд: Зургаан дэлбээт хүрэн дотор арабаар “Адл” (эрхэм дээд, хууль) гэж бичээд түүний дор нуман тамга дүрсэлжээ (Robert & Monica Tye, 1995: 141). Түүний гадуур байгаа дөрвөлжин хүрээний талуудаар “зарб Күндүз 618” (күндүзэд дэлдүүлэв 1221 он) гэсэн байна.

Энэ өгүүллийн Зураг 6-д оруулсан Чингис хааны мөнгөлсөн зэс зоосны нүүр талд мөн нуман тамга байгааг санахул нуман тамга Чингис хаантай эрхбиш холбоотой гэдэг нь харагдаж байна. Мөн Өгөдэй хааны мөнгөн зоос нуман тамгатай байдаг нь энэ тамгыг Чингис хаанаас залгамжилсан шинж чанартай бололтой. Ер нь XIII-XIV зууны монголын хаадын зоосон дээр нуман тамга цөөнгүй үзэгддэгийг энд тэмдэглэе.

Ар талд: Морьтой хүнийг ихэд өвөрмөц маягаар дүрсэлсэн байна.

Зураг 18.



Чингис хааны зэс зоос. Дэлдсэн он цаг, газрын нэр бичигдээгүй. 1221-1227 он. Газнигийн хийцтэй.

Каталог № А-1969.

Хэмжээ: 15 мм, 4.1 гр

Нүүрэн талд: “Эрхэм дээд Хаан бол хууль”

(Adl / Al - Khagan / Al - a'zm)

Ар талд: Багдадын Халиф Насирын нэр цолыг бичсэн байна (Album, 1998: 98).

Зураг 19.



Их Монгол улсад Чингис хааны үед гарсан зэс зоос. Маш ховор, өвөрмөц сонин зоосны нэг нь энэ байдаг.

Каталог № А-1970

Хэмжээ: 17 мм, 3.13 гр

Нүүрэн талд: Нэгэн амьтны дүрс байдгийг судлаачид үхрийн зураг гэж үздэг.

Хорезм хавийн орнуудад үхрийг иймэрхүү маягаар дүрсэлдэг байснаас үүдэн ийм дүгнэлт хийсэн бололтой. Үхрийн бие дээр “КУРРАМАН” гэж бичсэн байна. Энэ нь энэ зоосыг дэлдүүлсэн хотын нэр юм.

Ар талд: Багдадын Насирын нэр цол бичигджээ.



Зураг 20.



Чингис хааны зэс зоос. Дэлдсэн он цаг, газрын нэр байхгүй. 1221-1227 он.  
Газнигийн хийцтэй.

Каталог № А-1967А.

Хэмжээ: 18 мм, 2,9 гр

Нүүрэн талд: **“Аугаа Их Хаан. Курраман хог”**  
(Khagan / Al -mu a'zm / Kurraman)

Ар талд: Багдадын Халиф Насирын нэр цолыг бичсэн байна (Туге, 1995: 140).

Зураг 21.



Чингис хааны зэс зоос. Дэлдсэн он цаг, газрын нэр байхгүй. 1221-1227 он.  
Газнигийн хийцтэй.

Каталог № А-1969.

Хэмжээ: 22 мм, 3,5 гр

Нүүрэн талд: **Багдадын Халиф Насир**

Ар талд: Калима

1219-1227 оны хооронд гарсан монголын зоосууд дээр Чингис хааны нэр алдрыг дурдсан бичээстэй байдаг нь Их хаантай холбоотой өнөө үед үлдэж хоцорсон хамгийн биет бодит түүхийн дурсгал мөн.

### **НОМ ЗҮЙ**

*Давыдович Е.А.*, 1972. Денежное хозяйство Средней Азии после монгольского завоевания и реформа Масуда-Бека (XIII в). М. с. 132.

*Лихачев Н.П.*, 1928. Материалы для истории Русской и Византийской сфрагистики. Труды музея палеографии АН СССР. Вып 1, том I, с. 149. Ленинград.

*Нямаа Б.*, 2005. Монголын эзэнт гүрний зоосон мөнгө ба хаадын овгийн тамга. УБ.

- Петров П.Н.*, 2005. Тамги на монетах монгольских государств XIII-XIV вв. как знаки собственности. Труды международных нумизматических конференций. М., с. 173.
- Хэ Линь, Минь Су Цянь, Ту Шо*, 2003. Иллюстрированный каталог монет, отражающих национальные обычаи. Пекин. с. 616.
- Чунт Х.*, 2005. Чингис хааны анхны алтан шармал зоос, УБ., х. 15-30.
- Album Stephen*, 1998. A checklist of islamic coins. 2nd Edition. A-1969. p. 98. California.
- Spingler W.F.*, 1996. Hoard of Genghis Khan gold dinars recalls calamitous history. Newsletter. ONS. 147.
- Tye Robert & Monica*, 1995. "Jitals". A catalogue and Account of the coin denomination of daily use in medieval Afghanistan and West India. #334, p 141, Ilse of South Uist.

## SUMMARY

**B.Nyamaa**

### THE COINS OF CHINGGIS KHAN

Among the researches of the Great Mongol Empire, the coins of the Great Khans has received the least attention. This is due to the fact that researches in this field started much later than researches in other fields and the lack of research materials regarding the coins. Among the researches of the coins of the Mongol Empire, special attention should be paid to the coins of Chinggis Khan as source of historical and chronological evidence. We have about 20 different varieties of coins made up of gold, silver, and bronze that bare the name of Chinggis Khan. The coins of Chinggis Khan have been put into several different categories based on their material and legends.

- 1) AV dinars (Golden dinars) with the legends "Chinggis Khan-Greatest of Great Khans" and "Great Chinggis Khan".
- 2) AR dinar (Silver dinar) with the name and tamgha of Chinggis Khan.
- 3) AR dirham (Silver dirham) with the name of Chinggis Khan.
- 4) AE coins (copper or bronze) with legend of "By Decree of Great Chinggis Khan".
- 5) AE coins (copper or bronze) with the words "Khan" and "Khaqan".